

ТҮҮХ

**ХЯТАД-ЯПОНЫ ДАЙН БА
МОНГОЛЧУУД**

Л. ЛУВСАНЧҮЛТЭМ

19-р зууны 90-ээд оны орчим империалист гүрнүүд Хятад орныг эдийн засгийн талаар боолчлон түүний нутаг дэвсгэрийг хуваан авахын төлөө ширүүн тэмцэлдэж байв. Энэ үед капиталист ертөнц империалист шатанд гарч, дэлхийг хуваах тэмцэл нь дэлхийг дахин хуваах тэмцэл болон өрнөж, энэ тэмцлийн хамгийн чухал объект нь Хятад орон болов. Шинэ капиталист гүрэн-Япон чухамхүү Хятад орныг хуваан эзлэх хэрэгт «санаачлагчийн» ролийг гүйцэтгэсэн байна.

Хятад Япон хоёр өөрсдийн эрх ашгийн төлөө үргэлж тэмцэлдэн сөргөлдөж байсан нь 1894 оны (Бадаргуулт төрийн¹ 20 оны үед энэ тэмцэл асар их хурцдаж, гэнэт цэргийн мөргөлдөөн болон хувираад даруй дайн болсон бөгөөд энэ дайн байлдааны уршгаар монголчуудад учирсан хэлмэгдэл бага бус билээ. Түүнийг дор өгүүлнэ. Бээжин дэх Лифаньюанаас² дайн үүссэн тухай, мэдээг Халхын их хүрээнд Улаанбаатарт) суугаа Амбан-захирагчид яаравчлан мэдэгдэхийн хамт хааны зарлигийг уламжлан ирүүлжээ. Тэр зарлигт бичсэн нь: «Японы цэрэг ёс бусчилж, Манай тэнгисийн цэргийн хөлөг онгоцыг буудан гэмтээж, бидний эсрэг дайныг эхлэн явуулав. Иймд Монголоос үлэмжхэн тооны цэрэг гаргаж, дайсныг угтан байлдахад бэлтгүүлсүгэй. Одоо хүрээнд байгаа Шуан-Хуа цэргийг хорин хоногийн дотор байлдааны газар шилжүүлсүгэй»³ гэжээ. Үүнд Хүрээний Амбан тэр даруй өмнө замын буухиа 14 өртөөний захирал занги нарт яаран шавдан тушааж, өртөөний хүч нэмэгдүүлэхээр морь 1000, улаач 50-ийг говийн хошуудаас гаргуулж Шуан-Хуа цэргийн ангийг фронт руу илгээжээ. Монгол феодалууд Эзэн хааны зарлигийн дагуу өөрсдийн хошууны цэргийг яаравчлан дайчлан цуглуулж, байлдааны сургууль хийлгэхийн хамт Түшээт хан, Цэцэн хан аймгийн ард олноос залуу тарган, шилдэг сайн агт морь 3900-ыг албадан авч, Манж цэргийн уналгад зориулан явуулжээ.⁴

Тухайн үеийн Манжийн хаан төрийн дээд Хүрээний хүмүүс бол улс орноо батлан хамгаалж чадахуйц хүчийг эртээс зохион байгуулах чадваргүй байв. Ялангуяа цэргийн дарга нар нь шинэ цагийн цэргийн уран ухааны эрдэмгүй болхи бүдүүлэг байсан ба жир цэргийн олонхи нь зөвхөн нум сум, жад илд, бялтат буу, үхэр буу мэтийн дундад зууны үеийн зэр зэвсэгтэй буурай дорой цэргүүд байсан бөгөөд дайсантайгаа байлдан алалдахад үнэхээр эсрэг салхины өөд далбааг онгоц явуулах мэт маш бэрхтэй байсан ажээ. Тэгээд Манж цэрэг удалгүй далай тэнгис ба хуурай газар алин дээр ч дэс дараалан бут ниргэгдсэн тул Манж гүрэн даруй ялагдал хүлээжээ. Иймд Манжийн засгийн газар өөрийн газар нутаг Тайвань болон бусад хэд хэдэн арал хойгийг сайхь Японд өгч, дайны торгууль 3 сая лан мөнгө төлөх тухай хүнд хэцүү хэлэлцээрийг арга буюу

¹ Манжийн 11-р хааны оны цом

² Колонийн яам

³ УТТА Ф. I хн 1988

⁴ УТТА Ф. I хн 1990

хүлээн авчээ. Манж нар энэ торгуулийн зарим хагасыг дотоодын зээллэгээр төлөхөөс өөр замгүй байв. Иймийн тул 1897 оны 1-р сард Манж хаан тусгай зарлиг гаргав. Түүнд бичсэн нь «Тус улсын дотоодоос мөнгө зээлэн авч, урьдаар Японд өгөөд дараа нь мөнгө зээлдүүлсэн хүмүүст эргүүлж төлөх тул тамгатай бичиг, нэгэн зуун түмэн хуудас хэвлүүлж «бат илэрхийлэх тэмдэгт бичиг» гэж нэрлээд олон муж, аймаг, чуулган, хошуу, сумдад олгоно. Хуудас бүр 100 лан мөнгөний үнэтэй бөгөөд жил бүр 5 ли үржил хүү бодож, 20 жилийн дотор эх хүүгийн хамтаар төлөн дуусгана. Нийслэл хотноо байгаа ван, гүн ба гадаадад байгаа Жанжин, Сайдууд бичиг, цэргийн бүх түшмэд, хэн боловч цөм мөнгө зээлдүүлсүгэй, нийт ард иргэдэд зарлаж, мөнгө дуртайяа зээл өгвөл мөн хүлээн авсугай»⁵ гэгээ хүрээний амбан захирагч энэ зарлигийг хүлээн авмагц өөрийн захирсан бүс нутгийн аймгуудад зарлан мэдэгдээд Амбан өөрийн хувиас 1000 лан зээлдүүлж, монголчуудад «үлгэр жишээ үзүүлээд» Монгол ноёдын заримыг дуудан аваачаад «маш найрамдуу зөвлөсний» дээр Манж, Монгол олон түшмэдийг ухуулагчаар томилж, Монголчуудад болгоомжтой сайнаар ухуулсугай, албадаж болохгүй гэх зэргээр тушааж, хамгийн түрүүнд Монголын өндөр хэргэмтэн, тушаалтны дотор ажиллуулсанд халхын Түшээт хан аймгийн чуулганы дарга гүн Мишигдорж, дэд дарга гүн Паламдорж, жанжин бэйс Пүрэвжав, Эрдэнэ Шанзудба нарын зэрэг феодалууд манж амбаны яаманд биеэр ирцгээж хэлсэн нь: Эзэн хааны халамжилсан өршөөл ба төрийн хүртээсэн хишгийг санахгүй яахан зүгээр сууж болох билээ. Дотоодын зээллэгт манай аймгуудаас 200,000 лан мөнгө гаргаж буцалтгүй барьсугай, бат илэрхийлэх тэмдэгт бичиг (облигац авахгүй, хөхүүлэн шагнахыг хүсэхгүй)⁶ гэжээ.

Энэ зээллэгээг анхандаа зөвхөн ноёд түшмэдээс тэдний сайн дурыг харгалзан авах ёстой гэсэн атлаа сүүлдээ харин нийт ард албат нарт цөмд нь оноож, жинхэнэ татвар гувчуур мэт албадан авч байсан тул зарим мал хөрөнгө багатай ард мөнгө зээлүүлээс хэлтрүүлэхийг гуйж байсан боловч, хошууны захиргаа нь хаад түшмэдээс эхлээд харц албат хүртэл мөнгө өгөх ёстой. Ярих чалчихыг зогсоож, мөнгөө өг! гэж хариу тушаадаг тул ардууд сөрж хэлэлцэн чадахгүй, толгой бөхийн дагадаг байв. Бас ард олон зээллэгээний учир утгыг сайн мэдэхгүй дотор дотроо гайхалцаж, зарим хүн эзэн хаанд өргөн барих бэлгийн мөнгө гэнэ. Зарим нь Японд өгөх тусламжийн мөнгө гэнэ. Зарим нь шинэ алба татвар гэх буюу зарим нь гадаадад төлөх өрийн мөнгө гэх зэргээр өөр өөр ойлгож, янз янзаар ярилцаж байсан бөгөөд мөнгө өгөхөөс дургүйцэж татгалзах, хойргоших үзэгдэл олширч зээллэгээний явц удааширсан тул Манжийн сангийн яамнаас дүрэм заавар гаргаж их хэмжээний мөнгө авч чадсан «ухуулагч» нарыг шагнахаар зарласан тул ухуулах ажил нэн чангараад олон ухуулагчид мөнгө хураан авах гэж өдөр шөнөгүй нисэх мэт довтлон давхилдаж, айлуудын мал үргээж, нохой хуцуулан, ард олныг цухалдуулан нэхэмжилж байсан бөгөөд аглаг хөдөөгийн айлууд айж сандрахдаа аль сайн морь, саалийн үнээгээ барин өгч байжээ. Тэгээд энэ дайны торгуулийн төлбөрт зориулан халхаас хураан авсан мөнгө бүрэн бус мэдээгээр 400,000 лан болсон болой.⁷

Үүний нөгөөтэйгүүр Манж улс, империалист гүрнүүдийн нөлөөний хүрээнд ормогц гадаадын тагнуулчид Хятадын олон муж ба Ар, Өвөр Монголд олноор орж ирдэг болжээ. 1892 оны үеэс буюу Хятад Японы дайн гарахын өмнөхнөөс эхлэн гадаадын тагнуулын байгууллага өөрийн хүмүүсийг той-

⁵ УТТА Ф1 хн 1988. т 191—193

⁶ УТТА ф 8 хн-61,

⁷ УТТА. Ф 1 хн—67

рон аялж зугаалагчдын нэрээр халхавчлан Монголд оруулж байсан бөгөөд тэрхүү «зугаалагчид» Монголын олон хошуу, сумаар солбицон хэрэн хэсэх нь нэн олширчээ.

Хүрээний амбан захирагчийн Яамны дансанд үзвэл 1894—97 онд Бээжингийн Лифаньюанаас зам явах бичиг авч, Ар Монголд зугаалахаар ирсэн япон, герман, англи хүн 50 орчим байсны тал хувь нь япончууд байжээ. Эдгээрийн дотор худалдаачин, эмч, цэргийн түшмэл, оюутан, католик шашны лам нар хүртэл оролцон явж байсан бөгөөд тэд дугаараа Лифаньюанаас олгосон «Монголд зугаалахаар явна» гэсэн үг бүхий үнэмлэх бичиг барьж, дуртай газраар зорчин явж, хүн ард, газар орныг судлан, фото зураг авч байв. Ялангуяа Халх цэргийн анги, хаа хаа хэд, хичнээн байдаг ба ямар ямар зэр зэвсэгтэйг мэдэх гэж оролдохын хамт дайны тухай монгол хүний зан ааш ямар байгааг сүрхий ажиглан тагнаж байв.

Манж гүрэн хар тамхины 3 удаагийн дайнд ялагдаж аймшигтай хүнд хэлмэгдэл үзсэн явдал Манжийн төв, орон нутгийн түшмэдийн яс чөмгөнд шингэсэн мэт тэдний санаа сэтгэлээс гарахгүй болсон тул тэдгээр зугаалан явагчдыг тагнуулчид гэж тааварлавч гадаадтай дахин муудахаас болгоомжилж, тэдэнд саад хориг тавихгүй, харин зүй ёсны хүмүүс гэж зам явах бичиг олгож байснаар үл барам заримдаа тэдний очсон хошуудаас тусгай газарч хүн томилуулан өгдөг байсан төдийгүй бас заримд нь улаа, шүүс хэрэглэх эрх бүхий үнэмлэх олгож байсан удаа ч хааяа байв. Эдгээр тагнуулчид газар бүрээс янз бүрийн мэдээ авч байгаа байдал илэрсэн тул Манж нар аргагүй тэдгээртэй тэмцэх» болов. Жишээ нь:

Хүрээний амбанаас аймгуудад зарласан бичигт «саяхан Тянжингээс 20-30 япон хүн хувцас халж, гэзэг тавин, манай цэргийг тагнахаар гарчээ. Япон бол хятад бичиг мэдэх ба овор дүр дундад улсын хүнтэй адил. Тэд, манай ард иргэдийн дотор буюу сүм суурин газар нуун суух болзошгүй тул санаа сүвэгчилэн олж барьсугай»⁶ гэсэн ба бас Манж амбан өөрийн нүд чих болсон хүмүүсийг энд тэнд явуулан тагнуулыг мөрдөн эрүүлж байжээ. Гэвч олж барьсан баримт огт алга.

⁶ УТТА Ф. 1 хн—114